



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

106

1997 оны 3 дугаар
сарын 11 өдөр

Дугаар 6-62

Улаанбаатар
хот

Дүрэм батлах, ажилд томилох тухай

1. Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/18 тоот захирамжийг үндэслэн "Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газрын даргаар Дамдин овогтой Баасансүрэнг 1997 оны 03 дугаар сарын 16-наас томилж, сарын үндсэн цалинг 29500 төгрөгөөр, нэмэгдлийг үндсэн цалингийн 15 хувиар бодож тогтоосугай.
3. "Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар" байгуулагдсантай холбогдуулан "Нийслэлийн Хүүхдийн төлөө төв"-ийг 1997 оны 03 дугаар сарын 16-наар тасалбар болгон татан буулгасугай.
4. Нийслэлийн Хүүхдийн төлөө төвд ажиллаж байсан төрийн албан хаагчдыг батлагдсан орон тоо, цалингийн сангийн хэмт "Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар"-т шилжүүлсүгэй.
5. Нийслэлийн хороодод хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан арга зүйчдийг 1997 онд хотоос батлагдсан төсвийн дагуу ажиллуулахыг дүүргийн Засаг дарга нар, Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар (н.Баасансүрэн)-т зөвшөөрсүгэй.
6. Нийслэлийн Хүүхдийн төлөө төв татан буугдсантай холбогдуулан тус төвийн үндсэн хөрөнгийг Нийтлэг үйлчилгээний газарт шилжүүлсүгэй.
7. Нийслэлийн Хүүхдийн төлөө төвийн даргаар ажиллаж байсан н.Ширчмаа, "Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар"-ын дарга н.Баасансүрэн нарын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга	Д.Хадхүү	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүн	Х.Самбаа	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын боловсон хүчний эрхлэгч
	Б.Лхамсүрэн	-Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн зохион байгуулагч
	Ж.Оргил	-Нийтлэг үйлчилгээний газрын орлогч дарга

8. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Улаанбаатар хотын Хүүхдийн төлөө төв" байгуулах тухай Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 255 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Handwritten signature of J. Narantsetseg and the printed name **Ж.НАРАНЦАЦРАЛТ**.



НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн "Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар" (цаашид "газар" гэх) нь хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн талаар төрөөс явуулах бодлогыг нийслэлд хэрэгжүүлэх орон нутгийн төрийн захиргааны байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, холбогдох эрхийн актууд, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3. Нийслэлийн Засаг дарга нь уг газрын бүтэц, зохион байгуулалт, орон тоог багалж, даргыг томилж чөлөөлнө.

1.4. Тус газар нь Нийслэлийн засаг дарга, түүний Гамгын газрын харъяанд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.5. Газрын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол улсын хууль тогтоомж, удирдах дээд байгууллагын шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж биелэлтийг хангуулна.

1.6. Газрын даргын дэргэд холбогдох байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн удирдлагын зөвлөлийг байгуулан ажиллуулж болно.

1.7. Газрын үйл ажиллагаанд шаардагдох зардлыг нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

1.8. Нийслэлийн дүүрэг, хороодод хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн асуудал эрхэлсэн зохион байгуулагчдыг ажиллуулж байнгын удирдлагаар хангана.

1.9. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэр хуудсыг тогтоосон журмын дагуу хэрэглэнэ.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн талаар нийслэлээс баримтлах бодлого, энэ чиглэлээр гарсан хууль, үндэсний хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

2.2. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, залуу гэр бүлийн асуудлаар судалгаа хийж дүгнэлт гаргах, энэ чиглэлээр авах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх.

2.3. Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг асран хамгаалах, тусламж үзүүлэх, ажилгүй, хөдөлмөр эрхлээгүй залуучууд, эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

2.4. Харьяа аж ахуйн газрууд, анхан шатны байгууллагын ажилтнуудын үйл ажиллагааг эрхэлсэн асуудалд чиглүүлэн удирдан зохицуулах.

2.5. Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүдийн асуудлаар ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, дадлагажуулах ажлыг бодлогын дагуу зохион байгуулах.

2.6. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдэд зориулсан уран бүтээл, хэвлэл нийтлэл, мэдээлэл сурталчилгааны ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэх.

2.7. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн эрх ашгийг хөндсөн асуудлаар холбогдох байгууллагуудад зөвлөлгөө чиглэл өгөх, хамтран ажиллах.

2.8. Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүдийн зориулалттай баригдсан барилга, байгууламжийг зориулалтаар нь ашиглах, материаллаг баазыг бэхжүүлэх.

2.9. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийг хөгжүүлэхэд зориулсан төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

2.10. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахтай холбогдсон хөдөлмөрчдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч зохих газарт нь тавьж шийдвэрлүүлнэ.

Гурав. Газрын эрх

3.1. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн талаар явуулах төрийн бодлого, шийдвэр хөтөлбөрийг нийслэлд хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар санал боловсруулж нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх.

3.2. Эрхэлсэн асуудалтай холбоотой судалгаа мэдээ, баримт материалыг төрийн захиргааны болон бусад байгууллагаас тогтоосон журам, эрх хэмжээний хүрээнд гаргуулан авах.

3.3. Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн асуудлаар сургалт судалгаа, сурталчилгаа явуулах, зохион байгуулах.

3.4. Харьяа аж ахуйн нэгж байгууллагын дүрмийн хэрэгжилт үйл ажиллагааны тайлан, сонголыг авч хэлэлцэн үүрэг даалгавар өгч биелэлтийг нь хангуулах, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн удирдлагыг томилох, өөрчлөх, үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах.

3.5. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж дэхь хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан зохион байгуулагчдын үйл ажиллагаатай

холбогдсон асуудлыг бүх шатны засаг дарга, түүний Тамгын газартай хамтран шийдвэрлэх.

3.6. Баталагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах.

3.7. Нийслэлийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдтэй холбоотой асуудлаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх.

3.8. Нийслэлийн хууль тогтоомж, Засаг даргын захирамжаар хэрэгжүүлэгч агентлагуудад олгогдсон бусад эрх эдэлнэ.